



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/195

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Засгийн газрын болон Засаг даргын 2018- 2019 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн танилцуулга “Засаг даргын үйл ажиллагааны тайлан-2019” сэтгүүлийг хэвлүүлэх зардалд 5140,0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх 5140,0 мянган төгрөг /Таван сая нэг зуун дөчин мянган /-ийг аймгийн Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5.5-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/ -д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 00905

Аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр  
сарын 03-ны өдрийн А/195 дугаар  
захирамжийн хавсралт



№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Ховд-2019 сэтгүүл	ш	4000	1285	5 140 000
	НИЙТ				5 140 000

-оОо-